

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАР
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН

2021

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	3
ӨМНӨХ ҮГ	4
1 БҮЛЭГ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР	5
Аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	6
Аудитын иргэдийн бүлгийн үйл ажиллагаа, Авлигын эсрэг хөтөлбөрийн биелэлт	
2 БҮЛЭГ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЛААР	9
3 БҮЛЭГ ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЛААР	12
4 БҮЛЭГ НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЛААР	13
5 БҮЛЭГ ИТХ БОЛОН ӨӨРИЙН САНААЧИЛГААР ХИЙСЭН АУДИТЫН ТАЛААР	14
ДОТООД АЖЛЫН ТАЛААР	16
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	24
ДҮГНЭЛТ, САНАЛ	26

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

УИХ	Улсын Их Хурал
ТАБ	Төрийн аудитын байгууллага
ҮАГ	Үндэсний аудитын газар
ГАГ	Гүйцэтгэлийн аудитын газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ЖДҮДС	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан
МХС	Мал хамгаалах сан
СХС	Сум хөгжүүлэх сан
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЭДС	Тариалан эрхлэлтийг дэмжих сан
ББНШК	Баримт бичгийг нягтлан шалгах комисс

ӨМНӨХ ҮГ

Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын 2021 оны үйл ажиллагааны тайланг өргөн барьж байна.

Төрийн аудитын байгууллагын 2021 онд дэвшүүлсэн “Аудитыг цахимжуулж, нэгтгэн удирдах тогтолцоог бүрдүүлэн төлөвшүүлэх” гэсэн зорилтын хүрээнд тайлант онд 4 бүлэг 42 нэрийн ажлыг 17 орон тоотойгоор хийж гүйцэтгэлээ.

Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газраас цаасан хэрэглээнээс татгалзан байгууллагын үйл ажиллагааны танилцуулга, гүйцэтгэсэн аудитын мэдээллийг видео, инфографик, зурагт хуудас байдлаар www.audit.mn цахим хуудас болон “Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар” фейсбүүк хуудсаар дамжуулан олон нийтэд цахим хэлбэрээр мэдээлэл түгээж ажиллалаа.

Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар нь санхүүгийн тайлангийн аудитаар 198 санхүүгийн тайланд дүгнэлт өгч, 78 санхүүгийн тайланг түүвэрт хамруулан үзэж нэгдсэн удирдамжаар гүйцэтгэлийн 5, нийцлийн 1 аудит, өөрийн санаачилгаар гүйцэтгэлийн 3 аудитыг 3 ахлах аудитор, 6 аудиторын хүчин чадлаар 2785 хүн өдөр, 3540 илүү цаг ажиллаж, 272.9 сая төгрөгийн өртөгтэйгөөр хийж гүйцэтгэн орон нутгийн төсөвт 2,338.6 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна.

Төрийн хяналтын байгууллага үүсэж хөгжсөний 100 жилийн ой, нийгмийн хариуцлагын хүрээнд “Сайн үйлс”-ийн аян зохион байгууллаа. Мөн аймгийн төвд Алтайдаа сайхан амьдарцгаа



урин дор “Аудитын төгөл” нэртэй мод тарих, цэцгийн мандал, зүлэгжүүлэх ажил хийлээ.

Ковид-19 цар тахлын үед “Халдвараас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлын үед хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”-ны дагуу байгууллагын ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмол хийж, аудитын чанар, үр дүнг бууруулахгүйгээр аудиторыг цахим, танхимаар ажиллах хуваарь гарган ажиллуулж, тайлант жилийнхээ ажлаа бүрэн хийж гүйцэтгэлээ.

Манай байгууллагын хувьд төрийн аудитын байгууллагын шинэчлэл өөрчлөлтийн бодлого, үйл ажиллагааны чанар, үр өгөөжийг улам дээшлүүлэхийн төлөө хичээж ажиллахыг зорьж байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Х.ТҮВШИНБАЯР

1 БҮЛЭГ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

Төрийн аудитын байгууллагаас 2021 онд дэвшүүлсэн “Аудитыг цахимжуулж, нэгтгэн удирдах тогтолцоог бүрдүүлэн төлөвшүүлэх” зорилтын хүрээнд тайлант жилд 4 бүлэг 42 нэрийн ажлыг 17 орон тоотойгоор гүйцэтгэлээ.

Тус зорилтын хүрээнд цаасан хэрэглээнээс татгалзан байгууллагын үйл ажиллагааны танилцуулга, гүйцэтгэсэн аудитын мэдээллийг видео, инфографик, зурагт хуудас байдлаар www.audit.mn цахим хуудас болон “Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар” фейсбүүк хуудсаар дамжуулан олон нийтэд цахим хэлбэрээр мэдээлэл түгээж байна.

Үндэсний аудитын газар, аймгийн Засаг даргын тамгын газраас нэвтрүүлж буй цахим системүүдийг үйл ажиллагаандаа бүрэн нэвтрүүлсэн бөгөөд харилцагч болон шалгагдагч байгууллагуудтай www.eoffice.govi-altai.gov.mn сайтаар албан бичиг, цаг үеийн мэдээлэл солилцож байна.

Мөн байгууллагын шуурхайг zoom, teams цахим систем ашиглан хийж хэвшлээ.

Албан хаагчдын цаг ашиглалт, ажлын төлөвлөлт, гүйцэтгэл, хяналтыг able.audit.mn цахим системээр дамжуулан хянан удирдах, дотоод мэдээлэл солилцох зэргээр өдөр тутмын хэрэглээнд ашиглаж байна. Үндэсний аудитын газрын төрөлжсөн газруудаас IT, Viber group-т ирсэн мэдээллийг тухай бүр авч хэрэгжүүлэн цаг алдахгүйгээр мэдээлэл солилцож байна. Аудит хийх явцад багууд өөрсдөө групп нээж мэдээ, мэдээлэл, тулгамдаж байгаа асуудлыг тухай бүр нь шийдвэрлэж аудитыг хугацаанд нь чанартай хийж гүйцэтгэлээ.

Аудитын нэгдсэн удирдлага, бүртгэл мэдээллийн системд 14 хоног бүр хийгдэж байгаа гүйцэтгэлийн болон нийцлийн аудитын тайлангийн явцын мэдээг шивдэг. Мөн байгууллагын шуурхайг zoom, teams цахим систем ашиглан хийж хэвшлээ.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөнөөс гадна удирдах ажилтны семинар, хурал, зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх төлөвлөгөө, аудитын иргэдийн бүлгийн ажлын төлөвлөгөө, иргэдийн оролцооны стратеги төлөвлөгөө, харилцагч талуудын оролцооны төлөвлөгөө, авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, тасралтгүй сургалтын төлөвлөгөө, чанарын баталгаажуулалтын газраас өгсөн зөвлөмжийн хүрээнд хийх ажлын төлөвлөгөө, Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг тус тус боловсруулан хэрэгжилтийг хангаж ажиллалаа.

Аудитын үйл ажиллагааны талаар:

Говь-Алтай аймаг дахь Төрийн Аудитын газар нь санхүүгийн тайлангийн аудитаар 198 санхүүгийн тайланд дүгнэлт өгч, 78 санхүүгийн тайланг түүвэрт хамруулан үзэж, нэгдсэн удирдамжаар гүйцэтгэлийн 5, нийцлийн 1, өөрийн санаачилгаар гүйцэтгэлийн 3 аудитыг 3 ахлах аудитор, 6 аудиторын хүчин чадлаар 2785 хүн өдөр, 3540 илүү цаг ажиллаж, 272.9 сая төгрөгийн өртөгтэйгөөр хийж гүйцэтгэлээ.

Аудитын чанарын хяналтыг үе шат бүрд хэрэгжүүлэн батлагдсан маягтаар, санал зөвлөмжийг хавсралтаар гарган баримтжуулж ажилласан.

Манай байгууллагын хувьд нэгж байгууллагын үйл ажиллагаанд гүйцэтгэл, нийцлийн аудит хийхээс илүү аймгийн хэмжээнд анхаарал татсан, эрсдэлтэй байж болох сэдэвчилсэн аудит хийхийг зорилго болгон ажилласан. Тухайлбал: Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүд алдагдалтай ажиллаж байгаа нь орон нутагт ихээхэн анхаарал татсан асуудлын нэг байсаар байна.

Аймгийн хэмжээнд хэрэгжиж байгаа хөнгөлөлттэй зээл олгодог сангуудын үйл ажиллагаанд аудит хийж судалгаанд үндэслэсэн бодитой дүгнэлт, зөвлөмж өгөхийг зорьсон.

Төрийн аудитын газрын сүүлийн 5 жилийн үйл ажиллагааны үр дүнгийн харьцуулсан судалгааг хийж дүгнэж ажиллалаа.


Гүйцэтгэлийн аудитад 299 байгууллага, нийцлийн аудитад 879 нам, эсвэл, нэр дэвшигчид хамрагдсан байна.

Бид 2021 оны аудитаараа 49,739.8 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналтай холбоотой 6,746.3 сая төгрөгийн зөрчлийг залруулж 11,169.7 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 30,912.9 сая төгрөгийн зөрчилд 277 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлж, 910.9 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон байна.

Мөн УАГ-ын аудитын III газарт нэгдсэн удирдамжаар хийсэн "Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг", "Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн"-д хийсэн аудитаар илэрсэн зөрчлийг нэгтгэсэн тайланд тусгуулах 13 саналыг уламжилсан.

Тайлант жилд хийсэн аудит болон өмнөх оноос шилжин ирсэн шийдвэрийн үлдэгдлээс 2021 оны 12 дугаар сарын 21-ний байдлаар орон нутгийн төсөв, сангуудын болон байгууллагын дансанд 2,338.6 сая төгрөгийн төвлөрүүлж, 37,019.1 сая төгрөгийн үр өгөөж, 45 санхүүгийн бус үр өгөөжийг харилцагч байгууллагуудаар хүлээн зөвшөөрүүллээ. Ингэснээр аймгийн Төрийн аудитын газрын зардлын нэг төгрөгт ногдох хүлээн зөвшөөрөгдсөн үр өгөөж 61.15 төгрөг боллоо. (Дүрслэл-1)

Дүрслэл 1 Аудитын үр нөлөө





Аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:

СХС, МХС, ЖДҮДС, ТЭДС-гийн санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 797.2 сая төгрөгийн төлбөрийн актыг хариуцагч байгууллагаас Говь-Алтай аймгийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гарган хариуцагчаар төлүүлэхээр шүүхийн шийдвэр гарсан байна. Шүүхийн шийдвэр гарсан 797.2 сая төгрөгийг статистик мэдээний санхүүгийн тайлангийн аудит болон гүйцэтгэл, нийцлийн аудитын ТАБ СМ-2А, 2Б, 2В маягтаас хасагдсан хэсэгт тусгасан болно.

Аудитын тайлан холбогдох мэдээллийг хууль, журамд заасан хугацаанд www.audit.mn нэгдсэн цахим хуудсанд, шилэн дансны тухайд хуульд заасан мэдээллийг www.shilendans.gov.mn цахим хуудсанд бүрэн байршуулж ирлээ.

Аудитын иргэдийн бүлгийн үйл ажиллагааны талаар:

Аудитын иргэдийн бүлгийн үйл ажиллагааны төлөвлөгөөг 5 бүлэгт хамраарх 18 дэд ажил хийхээр төлөвлөж зорилтыг бүрэн хэрэгжүүллээ. Цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан аудитын иргэдийн бүлэгтэй хамтран ажиллахдаа утсаар ярих, и-мэйл солилцох, онлайнаар холбогдох гэх мэт цахим хэлбэрийг сонгон ажиллалаа. Тайлант онд хийсэн санхүүгийн тайлангийн танилцуулгыг иргэд олон нийтэд цахимаар мэдээлсэн.

Аудитын иргэдийн бүлгийн гишүүд санхүүгийн салбарын ахмад ажиллагсад болон аймгийн төсвийн ерөнхий нягтлан бодогчтой хамтран одоо ажиллаж байгаа нягтлан бодогчдод мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх цаашид анхаарах асуудлыг тодорхойлох төсвийн талаар цаг үеийн мэдээлэл өгөх зорилготой сургалтыг хамтран зохион байгуулсан.

Аудитын иргэдийн бүлгийн гишүүдтэй цахимаар уулзалтыг 4 удаа зохион байгуулж төрийн аудитын үйл ажиллагааг иргэд олон нийтэд хэрхэн түгээж ажиллах талаар санал солилцож аудитын байгууллагаас гарсан аудитын тайлан, санхүүгийн танилцуулга, үйл ажиллагааны тайланг фейсбүүк цахим орчинд түгээлээ. Одоогоор “Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар” хуудсыг 3900 хүн лайк дарсан, 140 хүн дагасан байна. Тайлант онд хийсэн санхүүгийн тайлангийн танилцуулгыг иргэд олон нийтэд цахимаар мэдээлсэн. Мөн өөрийн санаачилгаар хийсэн 3, нэгдсэн удирдамжаар хийсэн 6 гүйцэтгэлийн аудитын



тайлан, дүгнэлт, шийдвэрийг аудитын багтай хамтран инфографик, шторк байдлаар хийж олон нийтэд түгээлээ. Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар" фэйсбүүк хуудсаар олон нийтэд мэдээлсэн. Мөн иргэдийн бүлгийн үйл ажиллагааг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх зорилгоор фэйсбүүк групп нээн ажиллуулж байна.

Орон нутагт болсон "Орон нутгийн хөгжлийн сангийн 2020 оны үйл ажиллагаа"-ны талаар хэлэлцсэн төсвийн нийтийн сонсголд урилгаар оролцогч, ажиглагчийн байр сууринаас оролцон сангийн үйл ажиллагааны талаар тус үйл ажиллагаанд оролцогчдод ерөнхий мэдээлэл хийж иргэдийн төлөөлөл болон ард иргэдэд үр өгөөжтэй чанартай ажил хийх үе шатны хяналтыг сайжруулах шаардлагатай талаар үзэл бодлоо илэрхийлсэн нь өмнөх онуудаас онцлог шинэлэг зүйл байлаа.

Дүрслэл 2. Аудитын иргэдийн бүлгийн уулзалт



Дүрслэл 3. Нийтийн сонсгол




Авлигын эсрэг хөтөлбөрийн биелэлтийн талаар:


Авлигын эсрэг 2021 онд үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 8 бүлэг ажлыг хийж гүйцэтгэлээ. Авлигын эсрэг хууль тогтоомж, эрх зүйн актыг мэдээллийн самбарт мэдээлсэн бөгөөд албан хаагч нарт сургалт сурталчилгааны материалыг тарааж өгсөн. Мөн Авлигын эсрэг хууль тогтоомжийн талаар заавар чиглэл өгч, албан хаагч тус бүрд сургалт, мэдээлэл хийлээ.

Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3 дахь хэсэгт заасны дагуу 2021 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, авлигын эсрэг төлөвлөгөө, нууцаар хамгаалагдсанаас бусад 2020 оны санхүүгийн тайлангийн аудитын 202 тайлан, шийдвэр болон бусад 6 мэдээллийг www.audit.mn цахим хуудас болон <https://www.facebook.com/govialtai.audit> хуудсанд байршуулж олон нийтэд мэдээлэл хүргэлээ.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл, Прокурорын газраас зохион байгуулж буй "Судалъя, мэдье, сэргийлье" нөлөөллийн аяны удирдамжийг 2021 оны 06 дугаар сарын 21-ний өдөр хүлээн авлаа. Тус удирдамж нь 7 хоногийн хугацаанд хамт олны дунд сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж дараагийн байгууллагад хүлээлгэн өгөх зорилготой.




Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4, Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 9 дүгээр зүйл, Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийг хэрэгжүүлэх зорилгоор улирал, сар бүрийн төсөв, гүйцэтгэл, өмч хөрөнгө зарцуулсан шийдвэр зэрэг мэдээлбэл зохих 59 мэдээллийг www.shilendans.gov.mn сайтад бүрэн байршуулж улирлын тайланг хугацаанд нь илгээж байна.



Ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх, ёс зүйн дүрмийн мөрдөлт

- ✓ Тайлант жилд хийсэн санхүүгийн тайлангийн аудит, гүйцэтгэл, нийцлийн аудитаар нууцын баталгаа, ашиг сонирхлын зөрчилгүй тухай мэдэгдэл гаргуулсан. Түүнчлэн аудиторуд аудитыг гүйцэтгэхийн өмнө мэдүүлгийн маягтыг бөглөж хэвшсэн.
- ✓ Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль"-д заасан хориглолт, хязгаарлалтад хамаарч байгаа нэр бүхий 5 байгууллагатай холбоотойгоор Ашиг сонирхлын зөрчил үүссэн тухай мэдэгдлийг УАГ-ын Тамгын газарт хүргүүлж шийдвэрлүүлээ.
- ✓ Алба хаагчдын ХАСХОМ-ийн мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргуулан авч мэдүүлгийг www.meduuleg.iaac.mn цахим хуудсанд баталгаажуулсан.
- ✓ Олон нийтийн цахим сүлжээгээр авлигын эсрэг хууль тогтоомжийн талаар мэдээлэл байршуулж нөлөөллийн арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.
- ✓ Ёс зүйн хэм хэмжээг сахих, ашиг сонирхлын зөрчил, гэмт хэрэгт холбогдохоос урьдчилан сэргийлэн албан хаагчид тухай бүр зөвлөмж өгч байна. Түүнчлэн 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдөр "Ёс зүйн дүрэм", "Нөлөөллийн мэдүүлэг хөтлөх журам", "Эрүүгийн тухай хууль", "Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль"-аар нийт албан хаагч нарт сургалт хийсэн. Зөрчил гаргасан албан тушаалтан байхгүй болно.

2 БҮЛЭГ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЛААР



Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалтын дагуу Төсвийн тухай хуулийн 8.9 дэх заалтад хамрагдах 197 байгууллагын 281 санхүүгийн тайланд аудит хийхээс 160 санхүүгийн тайланд Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудиторуд, 41 санхүүгийн тайланд хувийн аудитын компаниар гэрээний үндсэн дээр аудит хийлгэхээр, ТЕЗ-ийн нэгтгэсэн тайлангаар 78 санхүүгийн тайланг түүвэрт хамруулахаар Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 60 тоот тушаалаар батлагдсан.

Төрийн аудитын газрын хэмжээнд төсвийн ерөнхийлөн захирагчийн 1, шууд захирагчийн 140, төсвийн төвлөрүүлэн захирагчийн 21, засгийн газрын тусгай сан, төсөл хөтөлбөрийн 24, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 12 нийт 198 санхүүгийн тайланд дүгнэлт гаргалаа.

Санхүүгийн тайлангийн аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын 8 аудитор, хувийн аудитын компанийн 3 аудитор нийт 2106 хүн өдөр, 2565 илүү цаг ажилласан тооцоо гарч байна.

Санал дүгнэлтийн хэлбэр

Аймгийн хэмжээнд нийт 281 санхүүгийн тайлан гарснаас:

- Аудит хийж дүгнэлт өгсөн 198:
 - Зөрчилгүй дүгнэлт 153
 - Хязгаарлалттай 42
 - Сөрөг 3
 - Дүгнэлт өгөхөөс татгалзсан 0
- Түүвэрт хамрагдсан 78
- Дүгнэлт гаргаагүй 1
- Аудитад хамрагдаагүй 4 санхүүгийн тайлан байна.

Аудитаар илэрсэн зөрчлийн ангилал

Нийт байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар 22,478.3 сая төгрөгийн зөрчил илрүүлж, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналтай холбоотой 6,740.1 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулан тайлагнуулсан.

Аудитын шийдвэр

Санхүүгийн тайлангийн аудитаар залруулагдаагүй 15,738.2 сая төгрөгийн зөрчлийн 886.9 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 6,661.8 сая төгрөгийн зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага, 47 албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага, 8,189.5 сая төгрөгийн зөрчилд 236 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлсэн байна. Мөн гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй 1 асуудлыг Монгол Улсын Ерөнхий аудиторт албан бичгээр хүргүүлсэн. Хуулийн хугацаанд аудит хийлгээгүй Монгол элсний Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн захиргааны дарга, нягтлан бодогч нарт хариуцлага тооцох албан бичгийг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлж хариуцлага тооцсон байна.

Аудитын үр дүн :

Тайланд жилд өгсөн жилд тогтоосон 886.9 сая төгрөг, өмнөх оны 1,241.3 сая төгрөгийн төлбөрийн актаас 1,433.79 сая төгрөгийн актыг барагдуулж 724,4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Мөн тайлант жилд өгсөн 6,661.7 сая төгрөг, өмнөх оны 232.1 сая төгрөгийн албан шаардлагаас 4,295.8 сая төгрөгийн албан шаардлагыг хэрэгжүүлж

1,568.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Ажлын хариуцлага алдсан 47 ажилтанд хариуцлага тооцох саналыг томилдог албан тушаалтанд хүргүүлснээс 44 албан тушаалтанд хариуцлага тооцсон байна. Өмнөх оноос шилжин ирсэн 9 албан тушаалтанд хариуцлага тооцсон байна. Биелэгдээгүй актын 45 хувийг СХС-гийн акт эзэлж байна.

Санхүүгийн тайлангийн аудитын үр нөлөө

Төсвийн ерөнхийлөн захирагч болон түүний харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитын тайлан, аудитын гэрчилгээг дээд шатны төсөв захирагчийг байлцуулан гардуулж, байгууллага тус бүрээр аудитын дүн, цаашид анхаарах асуудлын талаар нэгдсэн танилцуулга хийдэг болсноор бүх шатны байгууллагын төсвийн

хөрөнгийн зарцуулалт, түүнд тавих хяналт сайжирч, хариуцлага дээшилж байна.

Зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар албан шаардлага, зөвлөмж өгч хэрэгжилтийг үнэлснээр төсвийн байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаа сайжирч, төсвийн сахилга бат зохих хэмжээгээр дээшилж байна.

Санхүүгийн тайлангийн завсрын аудитын талаар:

Санхүүгийн тайлангийн аудитын хуваарийг санхүүгийн цахим системд бүрэн оруулсан. Санхүүгийн тайлангийн аудитыг гэрээгээр гүйцэтгүүлэхээр “Монголиан бизнес рейтинг ХХК-ны Говь-Алтай салбар, “Улиастай ван аудит” ХХК, “Шилэн баланс аудит” ХХК-тай гэрээ байгуулсан. Санхүүгийн тайлангийн аудитын төлөвлөлтийн өмнөх болон төлөвлөлтийн шатны ажилбар хийгдэж байна. Аймгийн төвийн байгууллагуудад төсөв захирагчийн шатлал бүрээр аудитын нээлтийг хийж аудитын захидлыг гардуулан өгөв. Сумдын байгууллагуудын “Аудитын захидал”-ыг сумдын санхүүгийн албадын дарга нарт и оффисс ашиглан хүргүүлээ.

Аудитын мөрөөр

Сум хөгжүүлэх сангийн зээлийн гэрээний хугацаа дууссан зээлдэгчдийн авлагад Шүүхийн шийдвэр гаргуулах, эвлэрлийн гэрээний хугацаа дууссан зээлдэгчийн авлагыг албадан барагдуулахаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн газартай гэрээ байгуулах талаар Прокурорын газарт судалгаа гаргаж хүргүүлсэн. Мөн Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангаас олгогдсон хөнгөлөлттэй зээлийн эргэн төлөлтийг хугацаанд нь төлөөгүй аж ахуйн нэгж байгууллагаас төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр аймгийн Прокурорын газарт хандан итгэмжлэлээр оролцуулж байна.


Өмнөх оны гүйцэтгэл, нийцлийн аудитаар өгсөн 17.1 сая төгрөгийг актыг барагдуулахаар аймгийн Цагдаагийн газарт хүсэлт гаргасан. Тус хүсэлтийн дагуу

аймгийн Цагдаагийн газрын Эдийн засгийн цагдаагийн ажилтан нь ажиллагаа явуулж Шүүхэд шилжүүлсэн байна. Мөн Сум хөгжүүлэх сангийн Санхүүгийн тайлангийн аудитын 812.5 сая төгрөгийн төлбөрийн актыг хариуцагч байгууллагаас Иргэний анхан шатны шүүхэд нэхэмжлэл гарган шүүхийн шийдвэр гарсан тул статистик мэдээнээс хасагдсан. Өмнөх аудитын шийдвэрийг хэрэгжүүлээгүй 3 байгууллагын 6 албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлж 6 хариуцлага тооцох албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Мөн удирдлага солигдсон 32 байгууллагад биелэлтийг хангуулах албан бичгийг, аймгийн Засаг даргад ТЕЗ-ын санхүүгийн нэгтгэсэн тайлангаар харьяа байгууллагуудын хэрэгжээгүй шийдвэрийг үлдэгдлийг хэрэгжүүлэх албан шаардлагыг хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Аудитын шийдвэрийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй 10 албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлснээс 2 албан тушаалтанд хариуцлага тооцсон байна. Мөн байгууллагын удирдлага, нягтлан бодогч солигдсон 4 албан тушаалтанд мэдэгдэл хүргүүлсэн байна.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ҮЗҮҮЛЭЛТ /2021/ ОН



197
байгууллагын
281
Санхүүгийн
тайлангаас




198
санхүүгийн
тайланд
дүгнэлт
гаргасан



78
Санхүүгийн тайланг
түүвэрт хамруулсан



22,478.3 сая
төгрөгийн
нийт алдаа
зөрчил
илрүүлсэн



6,740.1 сая
төгрөгийн
алдааг
залруулсан



15,738.2 сая
төгрөгийн
залруулагдаагүй
алдаа зөрчил
илэрсэн



886.9 сая
төгрөгийн
төлбөрийн
акт тогтоосон



6,661.8 сая
төгрөгийн албан
шаардлага
хүргүүлсэн



8,189.5 сая
төгрөгийн
зөвлөмж
хүргүүлсэн



47 албан
тушаалтанд
хариуцлага
тооцуулах
албан
шаардлага
хүргүүлсэн



Аудитыг 8
аудитор,
2 гэрээт
ажилтан ХАК
гүйцэтгэсэн



Аудитаар 10,994.6 сая
төгрөгийн
санхүүгийн үр өгөөж,
212 санхүүгийн бус үр өгөөж
бүртгэсэн

3 БҮЛЭГ ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЛААР



Тайлант онд УИХ-ын төсвийн байнгын хорооны захиалга, Үндэсний Аудитын газрын нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөрөөр “Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт”, “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль зохион байгуулах зардлын гүйцэтгэл”, “Төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо, чиг үүргийн хэрэгжилт”, “Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, үр нөлөө”, “Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн” -д гүйцэтгэлийн аудитыг 9 аудитор 374 хүн өдөр, 669 илүү цаг ажиллаж, 87.0 сая төгрөгийн өртөгтэйгөөр хийж гүйцэтгэсэн байна. Тайлант жилд хийсэн гүйцэтгэлийн аудитыг төлөвлөгөө, хөтөлбөрт тусгагдсан горим сорилыг бүрэн хэрэгжүүлж хугацаанд нь ҮАГ-ын Гүйцэтгэлийн аудитын газарт хүргүүллээ.

НЭГДСЭН УДИРДАМЖААР ХИЙСЭН АУДИТ:

3.1 “Улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт”-д хийсэн аудитын талаар:

Аудитад аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс, Санхүү төрийн сангийн хэлтэс, Орон нутгийн өмчийн газар, аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, аймаг болон сумдын ЗДТГ, бусад холбогдох байгууллага, хуулийн этгээд хамрагдлаа. Тус аудитыг 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөс 04 дүгээр сарын 30-ний өдрийг хүртэлх хугацаанд 3 аудитор 81 хүн өдөр зарцуулан, 243 цаг илүү ажиллаж 14.2 сая төгрөгийн өртөгтэйгөөр хийж гүйцэтгэсэн байна.

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ҮР ДҮН
Аудитаар “Улсын төсвийн хөрөнгө оруулалтад төсөвлөлтийн шаардлага хангахгүй төсөл арга хэмжээг баталснаар хөрөнгө оруулалтын тогтолцоо алдагдаж улмаар үр ашиг, үр нөлөөг бууруулсаар байна” гэсэн дүгнэлт 22,955.0 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 1,356.6 сая төгрөгийн зөрчил арилгуулах 8 заалт бүхий албан шаардлага, 18,079.6 сая төгрөгийн 8 заалт бүхий зөвлөмжийг холбогдох байгууллагуудад, 3,518.8 сая төгрөгийн 4 заалт бүхий саналыг ҮАГ-ын аудитын III газарт уламжилсан. Аудитын шийдвэрээс 21,598.4 сая төгрөгийн шийдвэр биелэгдэж, санхүүгийн үр өгөөжийг харилцагч байгууллагуудаар хүлээн зөвшөөрүүллээ. Аймгийн ЗДТГ-ын хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн тус хугацаанд 3 удаа солигдсонтой холбоотойгоор шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй байна. Аудитын шийдвэрийг хэрэгжүүлэх мэдэгдэл хүргүүллээ.

3.2 “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль зохион байгуулах зардлын гүйцэтгэл”-д хийсэн аудитын талаар:

Аймгийн Сонгуулийн хороо, сумуудын Сонгуулийн хороо, Улсын бүртгэлийн хэлтэс, Онцгой байдлын газруудыг хамруулан аудитыг 2021 оны 06 дугаар сарын 30-н өдрөөс эхлэн 07 дугаар сарын 09-ний өдөр хүртэл 3 аудитор 21 хүн өдөр зарцуулан, 42 цаг илүү ажиллаж 13.0 сая төгрөгийн өртөгтэйгөөр хийж гүйцэтгэсэн байна. Аудитын тайлан, дүгнэлт шийдвэрийг 2021 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 367 дугаартай албан бичгээр холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна.

3.3 “Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн”-д хийсэн аудитын талаар:

Аймгийн аймгийн Засаг дарга, түүний харьяа хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон асуудал эрхэлсэн байгууллагууд, ХХААГ, МХГ, ЭМГ, СХЗХ, ТББ, хүнсний сүлжээний бүх үе шатанд оролцогч хуулийн этгээд, иргэний аудитад хамаарал бүхий үйл ажиллагааг хамрууллаа. Тус аудитыг 2021 оны 09 дүгээр сарын 03-ны өдрөөс 11 дүгээр сарын 08-ны өдрийг хүртэлх хугацаанд 3 аудитор 81 хүн өдөр зарцуулан, 243 цаг илүү ажиллаж 13.4 сая төгрөгийн өртөгтэйгөөр хийж гүйцэтгэсэн байна.

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ҮР ДҮН

Аудитаар "Сонгууль зохион байгуулахтай холбоотой хуваарилагдан ирсэн санхүүжилтийг үр дүнтэй зарцуулсан байна." гэсэн дүгнэлт өгч 22.1 сая төгрөгийн зөрчил илрүүлж, аудитын явцад 6.2 сая төгрөгийн алдааг залруулж, 13.4 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага өгч, 2.5 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 15.8 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөжийг үр өгөөжийг бүртгэсэн. Аудитын шийдвэрийг 100 хувь хэрэгжүүлж, 15.8 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөжийг харилцагч байгууллагуудаар хүлээн зөвшөөрүүллээ.

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ҮР ДҮН

Аудитаар “Төсвийн хөрөнгийг үр дүнтэй зарцуулсан боловч хүнсний аюулгүй байдлыг хангах, хянах тогтолцоо хангалтгүй байна” гэсэн дүгнэлт өгч 22.1 сая төгрөгийн зөрчил илрүүлж, аудитын явцад 6.2 сая төгрөгийн алдааг залруулж, 13.4 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага өгч, 2.5 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 15.8 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөжийг бүртгэсэн. Мөн 8 заалт бүхий саналыг ҮАГ-ын аудитын III газарт уламжилсан. Аудитаар 120.9 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж, 11 санхүүгийн бус үр өгөөжийг бүртгэсэн. Аудитын шийдвэрийн хэрэгжилтийг ирүүлэх хугацаа болоогүй байна.

3.4 “Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, үр нөлөө дүн”-д хийсэн аудитын талаар:

“Төрөөс эмийн талаар баримтлах бодлого, эм, эмнэлгийн хэрэгслийн худалдаа, түгээлт, хяналтын талаарх зохицуулалт, “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого”-ыг үе шаттайгаар хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан тайлан, хяналт-үнэлгээний тайлан, зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн жагсаалтыг баталсан шийдвэр, үндэслэл, дээрх жагсаалтад орсон эмийн үнийн дээд хязгаарыг баталсан шийдвэр, санхүүгийн тайлан, анхан шатны болон бусад холбогдох баримт материалыг хамрууллаа. Тус аудитыг 2021 оны 09 дүгээр сарын 03-ны өдрөөс 11 дүгээр сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд 3 аудитор 103 хүн өдөр зарцуулан, 180 илүү цаг ажиллаж 19.5 сая төгрөгийн өртөгтэйгөөр хийж гүйцэтгэсэн байна.

3.5 “Төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо, чиг үүргийн хэрэгжилт”-д хийсэн аудитын талаар:

Аудитад аймгийн төрийн байгууллагуудын дотоод аудитын зорилго, зорилт, арга хэмжээг хариуцан хэрэгжүүлэх Төсвийн ерөнхийлөн захирагч болон тэдгээрийн харьяа агентлаг, байгууллагуудын дотоод аудитын үйл ажиллагааны мэдээлэл, тайлан, тоон өгөгдөл болон бусад нотлох баримтад үндэслэн дүн шинжилгээ хийж аудитыг гүйцэтгэлээ. Тус аудитыг 2021 оны 09 дүгээр сарын 03-ны өдрөөс 11 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд 3 аудитор 90 хүн өдөр зарцуулан, 97 цаг илүү ажиллаж 21.2 сая төгрөгийн өртөгтэйгөөр хийж гүйцэтгэсэн байна.

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ҮР ДҮН

Аудитаар “Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтыг чанартай хэрэгжүүлж, үр нөлөөг тооцож ажиллахаар байна” гэсэн дүгнэлт өгч 1,806.3 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 1,349.40 сая төгрөгийн зөрчил арилгуулах 110 заалт бүхий албан шаардлага, 7.6 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. Мөн 3 заалт бүхий саналыг ҮАГ-ын аудитын III газарт уламжилсан. Аудитаар 1,357.0 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж, 11 санхүүгийн бус үр өгөөжийг бүртгэж, 1,184.8 сая төгрөгийн үр өгөөжийг харилцагч байгууллагуудаар хүлээн зөвшөөрүүллээ. Аудитын шийдвэрийн хэрэгжилтийг ирүүлэх хугацаа болоогүй байна.

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ҮР ДҮН

Аудитаар “Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх дотоод аудитын нэгж буюу санхүүгийн хяналт аудитын алба нь байгуулагдсан цагаасаа хойш санхүүгийн хяналт шалгалт хийсэн боловч сангийн яамнаас гаргасан санхүүгийн хяналт шалгалтын стандартыг үйл ажиллагаандаа мөрдөөгүй, улсын салбарын дотоод аудитын аргачлалыг баримталж ажиллаагүй байна” гэсэн дүгнэлт өгч зөрчил арилгуулах 2 заалт бүхий албан шаардлага, 1 заалттай зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хүргүүллээ. Ажлын хариуцлага алдсан 1 ажилтанд хариуцлага тооцох саналыг томилдог албан тушаалтанд хүргүүлж хариуцлага тооцуулсан байна. Аудитаар 1 санхүүгийн бус үр өгөөжийг харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүллээ. Аудитын шийдвэрийг хэрэгжүүлэх хугацаа болоогүй байна.

4 БҮЛЭГ НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЛААР

Тайлант жилд “Нам эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын санхүүжилт түүний гүйцэтгэл”-д нийцлийн аудитыг 1 аудитор 10 хүн өдөр, 8.8 сая төгрөгийн өртөгтэйгөөр хийж гүйцэтгэсэн байна.

Эхний хагас жилд хийсэн нийцлийн аудитыг төлөвлөгөө, хөтөлбөрт тусгагдсан горим сорилыг бүрэн хэрэгжүүлж хугацаанд нь холбогдох газарт хүргүүлээ.



НЭГДСЭН УДИРДАМЖААР ХИЙСЭН АУДИТ:

4.1 “Нам эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын санхүүжилт түүний гүйцэтгэл”-д хийсэн аудитын талаар:

Аудитад аймаг, сумдын ИТХ-ын 2020 оны ээлжит сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчдийн аудитын дүгнэлт, дэлгэрэнгүй тайлан, маягтуудыг, харилцагч банкны дансны хуулга бусад шаардлагатай баримт материалыг хамруулсан.

Аудитын үр дүн :

Тайлант онд өгсөн зөвлөмж хэрэгжих шатандаа байна. Өмнөх оны 1,477.3 сая төгрөгийн төлбөрийн актаас 1,319.1 сая төгрөгийн актыг барагдуулж 158.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- ✓ Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитын үр дүнд хуулийн хэрэгжилтийн мэдээллийг цахим системд оруулсан.
- ✓ Мөн хуульд заасан мэдээллийг цэсэнд хугацаанд нь үнэн зөв байршуулбал мэдээлэл ил тод мэдээлэгдсэнээр зөрчил буурах сайн талтай.
- ✓ Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралтай хамтран “Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах” аяныг зарлан, төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн төсөв санхүүгийн үйл ажиллагааг ил тод болгох, Шилэн дансны тухай хуулийг олон нийтэд таниулах зорилгоор сургалт, нийтийн хяналтыг хэрэгжүүлэхээр төлөвлөж ажиллаад байна.
- ✓ Өмнөх оны шийдвэрийн хэрэгжилтийн үлдэгдэл Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн үлдэгдэл байна.
- ✓ Засгийн газрын тусгай сангаас олгосон зээл, хүү, алдангийг төлүүлснээр аймаг, сумдад ажлын байр нэмэгдүүлэх, үйлдвэр үйлчилгээ шинээр бий болгох хөрөнгийн эх үүсвэрийг бий болгох боломжтой болно.

НИЙЦЛИЙН АУДИТЫН ҮР ДҮН

Аудитаар 72.0 төгрөгийн зөрчил илрүүлж, аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэст, Татварын хэлтэст зөвлөмжийн хүргүүллээ. Аудитаар 1 санхүүгийн бус үр өгөөжийг бүртгэсэн. Зөвлөмжийн биелэлтийг ирүүлээгүй тул аймгийн Прокурорын газарт хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхгүй байгаа албан тушаалтан нарт хяналт тавих, зөвлөмжийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах албан бичгийг хүргүүлснээр тус газраас холбогдох албан тушаалтанд мэдэгдэл хүргүүлсэн.

Нийцлийн аудитын үр нөлөө

Аймаг, сумдын иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчид хандив өгсөн иргэн, хуулийн этгээдийг нийтэд зарласан.



Тайлант жилд өөрийн санаачилгаар “Орон нутгийн өмчит дулааны станцуудын үйл ажиллагаа, хөрөнгийн зарцуулалт”, “Орон нутгийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”, “Уул уурхайн ашигт малтмалын хайгуул, ашиглалт, нөхөн сэргээлтийн хэрэгжилт” -д гүйцэтгэлийн аудитыг 9 аудитор 295 хүн өдөр, 306 цаг илүү ажиллаж 63.1 сая төгрөгийн өртөгтэйгөөр хийж гүйцэтгэсэн байна. Тайлант жилд хийсэн гүйцэтгэлийн аудитыг төлөвлөгөө, хөтөлбөрт тусгагдсан горим сорилыг бүрэн хэрэгжүүлж хугацаанд нь аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга, холбогдох байгууллагад хүргүүлээ.

5.1 “Орон нутгийн өмчит дулааны станцуудын үйл ажиллагаа, хөрөнгийн зарцуулалт”-д хийсэн аудитын талаар:

Аудитад орон нутгийн өмчит 4 аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг хамруулан 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөс 06 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл 3 аудитор 165 хүн өдөр зарцуулан 120 цаг илүү ажиллаж 25.9 сая төгрөгийн өртөгтэйгөөр хийж гүйцэтгэсэн байна. Аудитад аймагт үйл ажиллагаа явуулж байгаа 4 орон нутгийн өмчит ААТҮГ-ын үйл ажиллагаа, хийгдсэн хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, ажлын гүйцэтгэлийг үнэлж дүгнэсэн баримт материал, өмч эзэмшлийн гэрээ, түүнийг дүгнэсэн байдал, үйлдвэр санхүүжилтийн төлөвлөгөө түүний хэрэгжилтийг төрийн захиргааны байгууллагаас үнэлж дүгнэсэн байдал, өмч хөрөнгийн ашиглалт хамгаалалттай холбоотой баримт материалыг хамруулан гүйцэтгэлээ.

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ҮР ДҮН

Аудитаар "Дулаан үйлдвэрлэгч орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудад үр дүнтэй хяналт тавьж, удирдлагын сахилга хариуцлагыг сайжруулснаар ашигтай ажиллах бүрэн боломжтой байна" гэсэн дүгнэлт өгч 1,275.5 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 1,254.9 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага өгч, 10.6 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 1,079.2 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөжийг бүртгэсэн. Аудитаар өгөгдсөн дээрх алдаа зөрчлийг дүгнэн үр дүнг тооцоход: Аудитын шийдвэрээс 10.6 сая төгрөгийн төлбөрийн акт, 1,122.9 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлагыг хэрэгжүүлж 747.8 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөжийг харилцагч байгууллагуудаар хүлээн зөвшөөрүүлээ.

5.2 “Орон нутгийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-д хийсэн аудитын талаар:

Аудитад аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс, Санхүү төрийн сангийн хэлтэс, Орон нутгийн өмчийн газар, аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, аймаг болон сумдын ЗДТГ, бусад холбогдох байгууллага, хуулийн этгээдийг хамруулан гүйцэтгэлээ. Аудитыг 2021 оны 05 сарын 01-ний өдрөөс эхлэн 3 аудитор 90 хүн өдөр зарцуулан, 60 цаг илүү ажиллаж 21.7 сая төгрөгийн өртөгтэйгөөр хийж гүйцэтгэсэн байна.

5.3 “Уул уурхайн ашигт малтмалын хайгуул, ашиглалт, нөхөн сэргээлтийн хэрэгжилт”-д хийсэн аудитын талаар:

Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Мэргэжлийн хяналтын газар, аймгийн ЗДТГ, сумдын ЗДТГ, бусад холбогдох байгууллага, тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагын холбогдох үйл ажиллагааг хамруулан гүйцэтгэлээ. Аудитыг 2021 оны 05 дугаар сарын 01-ны өдрөөс эхлэн 2 аудитор, 1 гэрээт ажилтан 40 хүн өдөр зарцуулан, 126 цаг илүү ажиллаж 15.5 сая төгрөгийн өртөгтэйгөөр хийж гүйцэтгэсэн байна

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ҮР ДҮН

Аудитаар "Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд тавих хяналтгүйгээс чанар муутай хөрөнгө бий болж, төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах үндэслэл болж байна" гэсэн дүгнэлт өгч 514.1 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 19.5 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага, 494.6 сая төгрөгийн зөрчилд зөвлөмжийг хүргүүлж, 19.5 сая төгрөгийн санхүүгийн, 6 санхүүгийн бус үр өгөөжийг бүртгэсэн. Ажлын хариуцлага алдсан 1 ажилтанд хариуцлага тооцох саналыг томилдог албан тушаалтанд хүргүүлж хариуцлага тооцуулсан байна. Аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж 495.5 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж, 1 санхүүгийн бус үр өгөөжийг харилцагч байгууллагуудаар хүлээн зөвшөөрүүлсэн. Аудитаар өгсөн албан шаардлага биелэгдээгүй бөгөөд аймгийн ЗДТГ-ын хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн тус хугацаанд 3 удаа солигдсон тул мэдэгдэл хүргүүлсэн.

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ҮР ДҮН

Аудитаар "Хариуцлагатай уул уурхайг бий болгон, бичил уурхайг дэмжиж, эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийг иргэдийн нөхөрлөлийн оролцоотойгоор хийж гүйцэтгэхээр байна" гэсэн дүгнэлт өгч 495.6 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 386.5 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага, 109.1 сая төгрөгийн зөрчилд зөвлөмжийг хүргүүлж, 495.6 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөжийг бүртгэсэн. Албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, 495.5 сая төгрөгийн санхүүгийн, 4 санхүүгийн бус үр өгөөжийг харилцагч байгууллагуудаар хүлээн зөвшөөрүүлээ.

ГҮЙЦЭТГЭЛ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ҮЗҮҮЛЭЛТ /2021 ОН/

 9 Гүйцэтгэсэн аудит	 8 Гүйцэтгэлийн аудит	 1 Нийцлийн аудит/өмнөх оноос шилжин ирсэн/
 27,117.5 төгрөгийн нийт алдаа зөрчил илрүүлсэн	 аудитыг 679 хүн өдөр 158.9 сая төгрөгийн өртөгтэйгөөр гүйцэтгэсэн	 13 асуудлын хүрээнд ҮАГ-ын III газарт санал уламжилсан
 57.87 сая Төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн	 4,507.0 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлсэн	 22,651.4 сая төгрөгийн зөвлөмж хүргүүлсэн
 Аудитад 1178 төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, нам, нэр дэвшигчид хамрагдлаа	 Аудитыг 9 аудитор, 1 гэрээт ажилтан гүйцэтгэсэн	 Аудитаар 24,042.3 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж, 1 санхүүгийн бус үр өгөөж бүртгэсэн

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ҮР ДҮНГИЙН ТАЛААР:

Тайланд жилд тогтоосон 24.0 сая төгрөг, өмнөх оны 368.2 сая төгрөгийн төлбөрийн актаас 108.7 сая төгрөгийн актыг барагдуулж 283.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Мөн тайлант жилд өгсөн 4,507.9 сая төгрөгийн албан шаардлагаас 1,522.9 сая төгрөгийн албан шаардлагыг хэрэгжүүлж 2,985.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Ажлын хариуцлага алдсан 2 ажилтанд хариуцлага тооцох саналыг томилдог албан тушаалтанд хүргүүлж албан тушаалтанд хариуцлага тооцсон байна. Биелэгдээгүй актын 38.9 хувийг Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын аудитаар тогтоосон гэрээгээр ажил гүйцэтгүүлсэн хувийн компаниудтай холбоотой акт эзэлж байна. Тайлант онд өгсөн албан шаардлагын хугацаа болоогүй байна.

6 БҮЛЭГ ДОТООД АЖЛЫН ТАЛААР

Бүтэц зохион байгуулалт, хүний нөөцийн талаар:

Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаалаар үндсэн 12 орон тоог баталж өгсөн бөгөөд байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах үйлчилгээний 5 ажилтантай нийт 17 орон тоотойгоор үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Төрийн жинхэнэ албан хаагчидтай гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж, үйлчилгээний албан хаагчидтай гэрээ байгуулж, улирал бүр ажлыг дүгнэлээ.


Төрийн албан хаагчдын хүний нөөцийг судалгааг гаргаж ҮАГ болон Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн. М.Атарцэцэгийн жирэмсний амралт авах хугацааг тооцон түр орлон ажиллуулахаар төлөвлөж Г.Санчирмааг гэрээт аудитораар дадлагажуулан сургаж бэлтгэсэн болно.

Сургалтын талаар:



Байгууллагын дотоод сургалтын төлөвлөгөөг сургалтын хэрэгцээ тодорхойлох хуудсаар санал авч 2021 оны сургалтын төлөвлөгөөг баталж хэрэгжүүлэн ажиллаж байна.

Дүрслэл 5. Сургалтыг бүтцээр харуулбал



Дотоод сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу суурь сургалт 9, хууль эрх зүйн сургалт 5, мэргэжлийн сургалт 8, гаднын сургалт 5 нийт 27 сэдвийн сургалт хийгдэж албан хаагчид хууль эрх зүй, стандарт журмын мэдлэгийг дээшлүүлсэн.

Дотоод сургалтын талаар:

Байгууллагын дотоод сургалтыг тогтмол хийснээр мэргэжлийн тасралтгүй сургалтыг чанаржуулж аудитын талбарын ажилбарыг үзүүлэх сургалт хэлбэрээр төрөлжүүлэн байгууллага дотроо туршлага солилцож мэдлэг мэдээллээ солилцож хэвшлээ. Эхний хагас жилд “Нөхөрсөг, шударга, ажил хэрэгч харилцааг эрхэмлэн эерэг хандлагыг төлөвшүүлэх” зорилготойгоор байгууллага, хамт олон, “Хувь хүний үнэ цэнэ”, “Мэргэжлийн үнэ цэнэ”, “Сонсох чадвар”, “Дэмжих ур чадвар” сэдвээр сургалт, хэлэлцүүлгийг зохион байгууллаа.

Сургалтыг хэлэлцүүлэг хэлбэрээр зохион байгуулснаар суралцагчийн идэвх оролцоо сайжирч, албан хаагчдын мэдлэг боловсрол дээшлэх, өөрийгөө танин мэдэх, хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж байна. Мөн ковид 19 цар тахлын байдалд байгаа энэ үед багууд цахимаар ажиллаж, цахим технологийг бие даан суралцаж, мэдлэг чадвараа дээшлүүлж байна.

ҮАГ-аас зохион байгуулсан сургалт:

ТАБ-ын хэмжээнд нэгдсэн байдлаар зохион байгуулагдсан сургалтуудад тухай бүр оролцон, өгсөн чиглэл арга зүйг хэрэгжүүлэн ажиллалаа. Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан тушаал, журмыг Able системээс татан авч тухай бүр судалж байна.

Сургалтын цөм хөтөлбөрийн хүрээнд цахимаар шинэ ажилтанд зориулсан “Төрийн аудитын байгууллагад шинээр ажилд томилогдсон албан хаагчдад зориулсан сургалт”, аудиторуудад зориулсан “хөгжлийн сургалт-МООС” сургалтыг бие даан нийт 196 удаа хандаж, 44 цаг 07 минутын хичээлүүдийг бие даан судалсан байна, нийт 208 удаа хандаж, 64 цаг 07 минутын хичээлүүдийг бие даан судалсан байна. Мөн дараах хэлэлцүүлэг, сургалтуудад хамрагдсан

- ✓ Шилэн дансны цахим системд санхүүгийн тайлангийн аудитаар шилэн данстай холбоотой илэрсэн зөрчлийг шивэх, байгууллагын 2020, 2021 оны статистик мэдээг шивэх практик сургалтыг зохион байгуулж албан хаагчид оролцсон.
- ✓ “Нөлөөллийн мэдүүлэг хөтлөх журам”, “Ёс зүйн журам”, “Аудит хийх журам”-ын сургалтуудыг ҮАГ-ын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газраас зохион байгуулж, аудиторууд бүрэн хамрагдлаа.
- ✓ Аудитын гуравдугаар газраас зохион байгуулсан “Хүнсний аюулгүй байдлын өнөөгийн үнэ цэнэ”, Төрөөс эмийн аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн”-д хийх аудитын урьдчилсан цахим хэлэлцүүлэгт албан хаагчид оролцлоо.
- ✓ “Төрийн албан хэрэг хөтлөлт”-ийн сургалтад 11 ажилтан оролцохоор саналаа хүргүүлэн, сургалтад бүрэн хамрагдлаа.
- ✓ Сүүлийн хагас жилд Статистик мэдээг local.audit.mn цахим системд оруулах практик сургалт, Хүний нөөцийн программын сургалт, Санхүүгийн тайлангийн аудитыг цахимаар хийхтэй холбогдсон fas.audit.mn/ программын сургалтуудад 11 албан хаагч бүрэн хамрагдсан. Мөн “Хүнс, эмийн аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн”-д хийх аудитын урьдчилсан

цахим хэлэлцүүлэгт Тэргүүлэх аудитор, аудитын менежер аудитын 1 ба 3 дугаар багууд оролцон, саналаа хүргүүлсэн.

- ✓ Төрийн аудитын үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах, аудитын үйл ажиллагаанд захиргааны ерөнхий хуулийг хэрэглэх, АТГ, ТЕГ-аас зохион байгуулсан ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд хүлээх албан тушаалын үүрэг хариуцлага, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдлэг олгох сургалт, төрийн болон албаны нууцын сургалтуудад 11 албан хаагч бүрэн хамрагдсан.
- ✓ “Эдийн засгийн бодлогын шинжилгээ” хичээлд 11 албан хаагч нийт 141 удаа хандаж, 40 цаг 37 минутын хичээлүүдийг судалж явцын сорил шалгалтаар А-2, В-6, С-2, D-1 үзүүлэлттэй өгсөн байна. Эцсийн сорил шалгалтыг авах хугацаа болоогүй байна.

Бусад сургалт:

СТА-ыг хийж гүйцэтгэхтэй холбоотойгоор аймгийн Төсвийн Ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланд нэгтгэгддэг байгууллагууд, Эрүүл мэндийн салбар, Боловсролын салбар, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, Татварын хэлтэс, ОНӨААТҮГ-ын удирдлага, санхүү нягтлан бодогч, мэргэжилтнүүдийг хамруулан уулзалт сургалтуудыг хийж гүйцэтгэсэн.

Ажилтан, албан хаагчид сурч хөгжсөнөөр өөрийгөө таньж мэдэж, өөрийн мөн чанар, үнэ цэнийг ойлгосноор өөртөө итгэлтэй болж, бусадтай эерэг харилцааг бий болгож, шинэ хандлага, зан чанаруудыг хөгжүүлж, мэргэжлийн ур чадваруудаа дээшлүүлэн, өмнөө тавьсан зорилтууддаа хүрч, амжилттай нэгэн болохоос гадна бусдад ч нөлөөлөх чадвартай болох давуу талтай. Тухайлбал:

- Худалдан авах ажиллагааны сертификат олгох АЗ-ийн сургалтад 9 албан хаагч хамрагдаж, 7 албан хаагч шалгалтдаа тэнцсэн.
- Байгууллагын 4 аудитор УБ хотод мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох шалгалтад орж 3 албан хаагч 3 шалгалтын, 1 албан хаагч 2 шалгалтын хөнгөлөлтийг авсан.
- Нэг албан хаагч IELTS-ийн сургалтад 1 сар хамрагдсан.

Мэдээ, мэдээлэл, судалгаа ил тод байдлын талаар:



Тайлант жилд хийсэн аудитын тайлан, зөвлөмжийг олон нийтэд мэдээлэх, байгууллагын үйл ажиллагааны талаар иргэдийг үнэн зөв мэдээллээр хангах зорилгоор дараах ажлуудыг зохион байгуулсан байна. Тухайлбал:

- ✓ Төсвийн байгууллагуудын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн 202 тайлан, 1 нийцлийн аудитын тайланг www.audit.mn сайт, "Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар" фэйсбүүк хуудсаар олон нийтэд мэдээлсэн.
- ✓ Тайлант онд гүйцэтгэсэн гүйцэтгэл, нийцлийн 9 аудитын тайланг www.audit.mn сайт, "Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар" фэйсбүүк хуудсаар олон нийтэд мэдээлсэн. Түүнчлэн гүйцэтгэсэн аудитын тайланг инфографик, шторк байдлаар олон нийтэд түгээж байна.
- ✓ Аудитын иргэдийн бүлгийн гишүүд аудитын тайлан, санхүүгийн танилцуулга, үйл ажиллагааны тайланг фэйсбүүк цахим орчинд түгээлээ. Одоогоор "Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар" хуудсыг 3900 хүн лайк дарсан, 140 хүн дагасан байна.
- ✓ Байгууллагын 2020, 2021 оны үйл ажиллагааны тайлан, статистик мэдээг ЯАГ-т хуулийн хугацаанд хүргүүлж хамт олонд танилцуулга, хэлэлцүүлэг хийлээ.
- ✓ Аймгийн Засаг даргын өргөтсөн хуралд сумын ИТХ-ын дарга, Засаг дарга нарт санхүүгийн тайлангийн аудитын дүн, өмнөх аудитын шийдвэрийн хэрэгжилтийн талаар танилцуулж цаашид анхаарах асуудлын талаар мэдээлэл өгч, Төрийн аудитын шинэчилсэн хуулийн найруулгаар сургалт хийсэн.
- ✓ Санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил, өгсөн шийдвэрээр шторк хийж цахим хуудсаар мэдээлсэн.
- ✓ Санхүүгийн тайлангийн танилцуулгыг бэлтгэж аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга нарт хүргүүлээ.
- ✓ Өмнөх онд хийгдсэн шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитаар инфографик бэлтгэж олон нийтэд мэдээлсэн.
- ✓ Байгууллагын 2020, 2021 оны үйл ажиллагааны тайланг "Алтайн мэдээ" сонинд нийтлүүлэн олон нийтэд хүргэсэн. Мөн аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга нарт 2020, 2021 оны үйл ажиллагааны тайланг хүргүүлээ.
- ✓ Завхан аймаг дахь төрийн аудитын газрын албан хаагчид туршлага солилцох нэгдсэн удирдамжаар хийгдэж байгаа аудитын талаар нээлттэй хэлэлцүүлэг, сургалтыг зохион байгуулсан.

Байгууллагын сервер, сүлжээ, компьютерын мэдээллийн аюулгүй байдлыг хангах, мэдээллийн технологийг аудитад ашиглах талаар дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

- ✓ Алба хаагчдыг 5 компьютероор хангаж дотоод сүлжээ, вирусийн эсрэг программыг суулгаж ажиллах нөхцөлийг бүрдүүллээ.
- ✓ Албан хэрэгцээнд байгууллагаас гарч буй албан бичиг, тайлан үг үсгийн алдаагүй байлгах зорилгоор "Болор дуран" программ хангамжийг 3 дахь жилдээ ашиглаж байна.
- ✓ Байгууллагын дотоод сүлжээний аюулгүй байдлыг хангаж сүлжээний гэмтэл, доголдолгүй хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэн ажилласан.
- ✓ Цахим архивын баяжилтыг хийлээ.
- ✓ Байгууллагын facebook цахим хаягаар аудиттай холбоотой санал, аудитын тайлан, дүгнэлтийг олон нийтэд тухай бүр нь мэдээлж байна.



Прокурорын байгууллагад:

Төрийн аудитын байгууллагаас гаргасан төлбөрийн акт, албан шаардлагатай холбоотойгоор маргаантай болон шүүхээр шийдвэрлүүлсэн хэрэг тус хугацаанд байхгүй болно.

Сум хөгжүүлэх сан, мал хамгаалах сан, тариалан эрхлэлтийг дэмжих сан, жижиг дунд үйлдвэрлэл эрчимжсэн газар тариалан, жимс жимсгэнэ, хүлэмжийн аж ахуйг дэмжих зорилгоор хоршоо, иргэдэд олгосон 1,730.4 сая төгрөгийн зээлийн төлөлт хийгдээгүй төр хохирч байгаа үйлдэлд төрийн төлөөлж хохирлыг барагдуулах албан бичгийг хүргүүлсэн.

Тус албан бичгийн хүрээнд Прокурорын газар ажиллагаа хийгдэж анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргаж 44 иргэнтэй холбоотой 212.6 сая төгрөгийн шүүхийн захирамж гаргуулсан байна. Эдгээр сангуудын дансны хуулгыг боловсруулахад 463.1 сая төгрөгийн зээлийг төвлөрүүлсэн байна.

Өмнөх онд Прокурорын байгууллагад шилжүүлсэн гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй асуудлуудын хувьд “Солонго Дулааны станц” ААТҮГ-тай холбоотой асуудлыг Авлигатай тэмцэх газар, “Газрын тухай хууль” зөрчсөн үйлдэлд аймгийн Засаг даргыг холбогдуулан шалгуулахаар Нийслэлийн прокурорын газарт хяналт тавиулахаар шилжүүлсэн байна. Эхний хагас жилд санхүүгийн тайлангийн аудитаар гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй 1 асуудлыг Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу Монгол улсын Ерөнхий аудиторт хүргүүлсэн бөгөөд шаардлагагүй гэж үзсэн бөгөөд төсөв захирагчид хариуцлага тооцуулах саналыг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлж хариуцлага тооцсон байна.

Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлд заасны дагуу албан тушаалтны төрд учруулсан хохирлын судалгааг хийж байгаа бөгөөд 2017-2020 оны аймгийн шүүхээр шийдвэрлэгдсэн төрийн албан хаагчийн нөхөн олговортой холбоотой судалгааг гарган бааз үүсгээд байна. Урьдчилсан байдлаар 116 удаагийн шүүхийн шийдвэрээр 545.5 сая төгрөгийн хохирол төрд учруулсан байна. Түүнчлэн Прокурорын байгууллагатай хагас бүтэн жилээр харилцан мэдээлэл солилцохоор шийдвэрлэсэн.

Цагдаагийн газарт:

Цагдаагийн газарт 2021 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 23 дугаартай албан бичгээр захиргааны шийдвэр гүйцэтгэлд туслалцаа авахаар хандан Төрийн аудитын байгууллагаас гарсан аудитын шийдвэрийг хэрэгжүүлэхээр хамтран ажиллаж байна. Тус хүрээнд 2 төлбөрийн акттай холбоотой асуудалд ажиллагаа хийгдэж байна.

Татвар, Нийгмийн даатгалын хэлтэст:

Тайлант жилд хийсэн санхүүгийн тайлангийн аудит, гүйцэтгэлийн аудитаар татварын хууль тогтоомж зөрчсөн 3 асуудлын хүрээнд 8,128.3 сая төгрөгийн, нийгмийн даатгалын шимтгэлтэй холбоотой 2 асуудлын хүрээнд 15.2 сая төгрөгийн зөрчилд хяналт хийж зөрчил арилгуулах албан бичгийг аймгийн Татварын хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэст тус тус хүргүүллээ. Нийгмийн даатгалын улсын байцаагч хяналт шалгалт хийж зөрчлийг бүрэн арилгуулсан.

Татварын хууль тогтоомж зөрчсөн асуудлын хүрээнд биелэлт хангалтгүй байсан тул “Зөвлөмжийг үнэлэх давтан аудитын удирдамж”-ын дагуу давтан аудитыг хийж гүйцэтгэсэн. Давтан аудитаар И баримтгүй зөрчлийн 96 хувь, татварын тодорхойлолтын зөрүүг арилгах зөрчлийн 44 хувь, хөдөлмөрийн чадвараа түр алдсан 4 иргэнтэй холбоотой зөрчлийг бүрэн арилгасан.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн холбогдох заалтыг зөрчсөн нам, нэр дэвшигчид Зөрчлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 заасны дагуу арга хэмжээ авч ажиллаагүй байлаа.

Биелэгдээгүй шийдвэрийг 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор хяналт шалгалт хийж арилга 3 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлсэн. Зөвлөмжийг дагуу И баримттай холбоотой зөрчлийг бүрэн арилгасан байна.

Архив, албан хэрэг хөтлөлтийн талаар :



Тайлант жилд байгууллагын албан хэрэг, хөтлөлтийн талаар дараах ажлуудыг зохион байгууллаа.

- ✓ Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг MNS-2011:2140 баримт бичгийн стандарт, Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар, Байгууллагын архивын ажлын үндсэн зааврын дагуу зохион бүрдүүлж хөтлөн явууллаа.
- ✓ Албан хэрэг хөтлөлтийн ABLE программыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, өдөр тутамдаа ашиглаж байна.
- ✓ Байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг боловсруулахдаа ТАБ-ын 2019-2024 онд хэрэгжүүлэх стратеги, Харилцагч талуудын оролцооны стратеги төлөвлөгөө, Сургалт хөгжлийн стратеги хөтөлбөр, төлөвлөгөө зэрэг бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан боловсрууллаа.
- ✓ Тайлант жилийн 12 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар 328 албан бичиг ирснээс 21 хариутай бичигт хариуг хүргүүлж, 915 албан бичгийг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна.
- ✓ Хэвлэмэл хуудсыг тушаалаар индексийн дагуу дугаарлан, холбогдох стандарт журам, зааврыг мөрдөн албан хэрэг хөтлөлтөд ашиглаж байна. Байгууллагын хэмжээнд оны эхэнд 1651 төлбөрийн акт, 3167 албан шаардлага, 123 тэргүүлэх аудиторовн тушаал, 1310 А4, 1259 А5 албан тоотыг хэвлүүлж, 807 төлбөрийн акт, 3158 албан шаардлага, 119 тэргүүлэх аудиторовн тушаал, 1296 А4, 1222 А5 албан

тоотыг үйл ажиллагаандаа хэрэглэж, төлбөрийн актын 824, албан шаардлагын 31, тэргүүлэх аудиторын тушаал 9, А4-12, А5-37 албан тоотын үлдэгдэлтэй байна.

- ✓ Аудитын үйл ажиллагаа, тайлан шийдвэртэй холбоотой 19 баримт материалыг хуулбар үнэн тэмдгээр баталгаажуулан хүсэлт гаргасан байгууллага, иргэнд өглөө.
- ✓ Байгууллагын 2020-2021 оны хөтлөх хэргийн жагсаалтын дагуу байнга хадгалах 342, түр хадгалах 3 баримтыг байгууллагын архивд хүлээн авсан байна.
- ✓ Байгууллагын 2021 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг боловсруулан баталлаа.
- ✓ Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд ББНШК-оос төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ. ББНШК 2021 оны 05 дугаар сарын 25-ны хуралдаанаар хяналт шалгалтыг хэлэлцэн ажлын тайланг баталж цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойллоо. Хяналт шалгалтаар бичиг хэргийн ажилтанд 7 заалт бүхий зөвлөмжийг өглөө.

Өргөдөл гомдол

Тайлант жилд байгууллагын хэмжээнд санал, гомдол ирээгүй, аудиттай холбоотой 5 хүсэлт, 7 албан хаагчийн өргөдлийг шийдвэрлэсэн байна. Тайлант жилд байгууллага, иргэдээс 5 өргөдөл ирснээс хуулийн хугацаанд шийдвэрлэж хариу хүргүүлсэн. Жирэмсэн амаржсаны амралт, Улаанбаатар хотод нарийн мэргэжлийн шинжилгээ, үзлэгт хамрагдах 3 ажилтны өргөдлийг шийдвэрлэсэн байна. Хариутай бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн эргэлтийн мэдээг сар бүр тогтмол гарган хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Мэдээлэл солилцох урсгал

Монгол Улсын Ерөнхий аудитор, ерөнхий аудиторын орлогчоос өгсөн үүрэг чиглэл, төрөлжсөн аудитын газраас болон бусад газруудаас ирүүлсэн албан бичиг, судалгаа, саналыг тухай бүр хэрэгжүүлэн ажиллалаа. Үүнд:

- ✓ Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаал, удирдах ажилтны зөвлөгөөн, семинар, хурал зөвлөгөөнөөс өгсөн үүрэг чиглэлийн дагуу төлөвлөгөө гарган гүйцэтгэлд хяналт тавьж хэрэгжилтийг хангаж ажиллалаа.
- ✓ Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангаар, Чанарын баталгаажуулалтын газраас өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн дагуу төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангаж ажиллалаа.
- ✓ Аудитын III газарт хандаж "Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг", "Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, үр нөлөө", "Төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо, чиг үүргийн хэрэгжилт", "Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн "-д хийх гүйцэтгэлийн аудитын акт, албан шаардлагын төслийг хянуулж зөвлөгөө авлаа.
- ✓ Аудитын III газраас нэгдсэн удирдамжаар хийгдэж байгаа 3 гүйцэтгэлийн аудитын 6 цахим сургалт хэлэлцүүлэгт албан хаагчид бүрэн хамрагдсан.
- ✓ Мэдээлэл технологийн газраас хийгдэж байгаа шилэн дансны программд 281 байгууллагын мэдээллийг бүрэн орууллаа. Мөн хүний нөөцийн цахим системд алба хаагчдын мэдээллийг бүрэн шивж оруулсан. Санхүүгийн тайлангийн аудитын 5 удаагийн программын сургалтад албан хаагчид бүрэн оролцсон.

- ✓ УАГ-аас ирүүлсэн цаг үеийн үүрэг, даалгавар, мэдээ, судалгаа, шийдвэрлэлтийг бүртгэж, шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллаж байна.
- ✓ Хүний нөөцтэй холбоотой тушаал шийдвэрүүдэд холбогдох хууль, журмуудыг ашиглан, хүний нөөцийн бүртгэлийн системийг нэвтрүүлж байна. Хүний нөөцийн нэгдсэн системийн программ шинэчлэгдсэн ба үүнээс сангийн яамны цахим хуудсанд татагдан ажилтан албан хаагчийн цалинг бодож байгаа.
- ✓ Teams программаар 14 хоног тутмын аудитын мэдээ, үйл ажиллагааны тайланг 14 хоног тутамд Захиргаа удирдлага газарт хүргүүлж байна.
- ✓ Байгууллагын 15 хоног бүрийн шуурхай хурлаар өгсөн үүрэг даалгаврын бүртгэл хөтлөн, биелэлтийг тооцож байна.
- ✓ Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг улирал бүр гаргаж УАГ-т хүргүүлсэн.
- ✓ УАГ-ын төрөлжсөн газруудаас хийсэн цахим сургалт, хэлэлцүүлэгт тухай бүр нь албан хаагчдаа бүрэн хамруулсан.

Шинэ коронавируст цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх ажлын талаар:

Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан 5 заалт бүхий тушаал, “COVID-19” цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлын үед хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргаж хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

- ✓ Ажлын байрны ариутгал цэвэрлэгээг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлж, албан хаагчдын дархлааг дэмжих, халдвараас урьдчилан сэргийлэх ажлуудыг зохион байгууллаа.
- ✓ Ковид-19 өвчин эхлэхээс эхлэн албан хаагчдын явах газрын маршрут гаргасан, биеийн халууныг хэмжүүлэн биеийн байдлыг хянасан.
- ✓ Аймагт халдварт өвчлөл гарч, хөл хорио тогтоох үед бүх албан хаагчдыг шинжилгээнд хамруулсан.
- ✓ Албан хаагчдыг I, II, III тун вакцинд бүрэн хамруулсан.
- ✓ Халдвар хамгааллын дэглэмийг баримталж, орон нутгаас гарсан шийдвэрийн дагуу цахимаар болон танхимаар ажиллах хуваарь гарган албан хаагчид мөрдөн ажиллаж байна.
- ✓ Албан хаагчдын биеийн халууныг өглөө бүр үзэж тэмдэглээг хийж нэвтрүүлэх, өвчний шинж тэмдэг илэрвэл гэрт нь буцаах зарчмыг баримтлан ажилласан.
- ✓ Ажлын байранд амны хаалтгүй гаднын этгээдийн нэвтрүүлэхгүй байх, шаардлагатай тохиолдолд амны хаалт, халууны үзлэг хийж, уулзалтын бүртгэл хөтөлж, асуумж бөглүүлэн 1 албан хаагчтай уулзах хүмүүсийг дараалуулан оруулж хэвшлээ.
- ✓ Байгууллагын албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд бүрэн хамруулж эмчлүүлэх шаардлагатай 3 албан хаагчид эмчийн жорын дагуу эмчилгээг хийлгэсэн. Мөн “В”, “С” вирусийн шинжилгээнд 17 албан хаагчдаа бүрэн хамруулж вакцинд хамрууллаа.

Албаны нууцтай холбоотой хэрэгжүүлсэн ажил

Төрийн аудитын байгууллагын төрийн болон албаны нууцыг хамгаалах дотоод журмын хэрэгжилтийн дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

- ✓ Холбогдох журмын дагуу нийт албан хаагч нараас 2021 оны 01 дүгээр сард төрийн болон албаны нууцын баталгаа гаргуулан авч заавар зөвлөгөө өгч ажиллалаа. Түүнчлэн аймгийн Тагнуулын хэлтсээс ирүүлсэн зурагт хуудсыг тарааж урьдчилан сэргийлэх арга хэмжээг авсан.
- ✓ Төрийн нууцтай холбоотой 2 санхүүгийн тайлангийн аудитыг аймгийн Тагнуулын газарт холбогдох хууль, журмын дагуу хийж гүйцэтгэсэн.
- ✓ Нууцтай холбоотой аудитын тайлан бусад баримт материалыг нууцын өрөөний сейфт хадгалсан.

Ажилдаа нэвтрүүлсэн шинэлэг ажлууд, бидний амжилт

Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар нь эхний хагас жилд онцлон дурдвал дараах шинэлэг, бүтээлч ажлуудыг хийж хэрэгжүүлсэн. Тухайлбал:

- ✓ Ковид-19 цар тахлын үед ажилтнуудын ажиллах нөхцөл бололцоог ханган ажиллаж аудитыг хугацаанд нь чанартай, үр дүн, үр өгөөжийг бууруулахгүйгээр дэвшүүлсэн зорилтоо биелүүлэн ажилласан.
- ✓ Аудитад ашиглах цахим мэдээллийн дундын сан үүсгэн олон нийтийн сүлжээ, мэдээллийн хэрэгсэлд тавигдсан мэдээллийг цуглуулж байна.
- ✓ Цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан аудитын горим сорил, тулган баталгаажуулалтыг цахимаар хийж байна.
- ✓ “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”-д хийсэн нийцлийн аудитын тайлангаар инфографик хийж цахим сүлжээгээр байршуулсан.
- ✓ Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын аудитыг хийхдээ сүүлийн 5 жилийн хөрөнгө оруулалтын судалгааг хийсэн. Тэдгээр төсөл арга хэмжээний өнөөдрийн ашиглалт, ард иргэдэд өгч байгаа үр өгөөжийг тооцож дүгнэлт зөвлөмжийг боловсруулсан.
- ✓ Орон нутагт болсон "Орон нутгийн хөгжлийн сангийн 2020 оны үйл ажиллагаа"-ны талаар хэлэлцсэн төсвийн нийтийн сонсголд урилгаар оролцогч, ажиглагчийн байр сууринаас оролцсон.
- ✓ Тайлант жилд хийгдсэн аудитын шалгагдагч этгээдүүдээс аудитын илрүүлэлт, тухайн байгууллагад үзүүлсэн үр нөлөө, аудитуудын ёс зүй, харилцаа хандлагын талаар Google form-оор гадаад санал асуулга авч үнэлэлт дүгнэлт өгч ажиллалаа. Мөн дотоод санал асуулгаар албан хаагчдын харилцаа, хандлагын үнэлгээг хийлгэн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг нэг үзүүлэлт болгон дүгнэлээ.
- ✓ Гүйцэтгэх албан тушаалын тусгай шалгалтад 1 албан хаагч амжилттай хамрагдсан. Бичиг хэргийн ажилтны туршилтын хугацаа дуусаж жинхэлсэн.
- ✓ Нөхөрсөг, шударга, ажил хэрэгч харилцааг эрхэмлэн эерэг хандлагыг төлөвшүүлэх зорилготойгоор байгууллага, хамт олон, хувь хүний үнэ цэнэ сэдвээр сургалт, ажиллагсдын эрүүл мэндийн болон харилцаа хандлага, спортын чиглэлээр сургалт, хэлэлцүүлэг, аяллын зохион байгуулсан.
- ✓ Манай байгууллагын хамт олны дундаас ажил бүтээлээр шалгарч “Төрийн хяналтын тэргүүний ажилтан” цол тэмдгээр ахлах аудитор Д.Цэрэнханд, УАГ-ын

“Хүндэт Жуух бичиг”-ээр нярав, үйлчлэгч Д.Энх-Оюун, Сангийн яамны “Санхүү, банкны тэргүүний ажилтан цол тэмдэг”-ээр аудитор Э.Сүнжидмаа, Сангийн яамны “Жуух бичиг”-ээр аудитор М.Атарцэцэг нар шагнагдлаа.

- ✓ Байгууллагын 4 аудитор Улаанбаатар хотод мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох шалгалтад орж 3 албан хаагч 3 шалгалтын, 1 албан хаагч 2 шалгалтын хөнгөлөлт авсан.
- ✓ Худалдан авах ажиллагааны сертификат олгох А-3-ийн сургалтад 9 албан хаагч хамрагдаж, 7 албан хаагч шалгалт өгч тэнцсэн.
- ✓ Төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо, чиг үүргийн хэрэгжилт”, “Орон нутгийн өмчит дулааны станцуудын үйл ажиллагаа, хөрөнгийн зарцуулалт”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар баруун бүсийн судалгаа хийж дүгнэлт өгсөн.
- ✓ Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралтай хамтран “Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах” аяныг зарлалаа.
- ✓ Аудитаар илэрсэн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх, аудитын шийдвэрийг хэрэгжүүлэх аймгийн Засаг даргын 02 тоот албан даалгавар гаруулан хэрэгжилтийг хангуулан ажиллалаа.

Төрийн хяналтын 100 жилийн ойн арга хэмжээний хүрээнд

Монгол улсад Төрийн хяналтын байгууллага үүсэж хөгжсөний түүхт 100 жилийн ойг угтан сайн үйлсийн аян зохион байгуулж эх үрсийн баяраар зорилтот бүлгийн 3 өрхөд нэн шаардлагатай хоол хүнс, ахуйн хэрэглээний тусламжийг гардуулан өглөө. Мөн хөгжлийн бэрхшээлтэй нэг хүүхдэд баяр ёслол тэмдэглэлт өдрүүдээр тусламж үзүүлж байна.

Ногоон Алтай-Бидний Алтай” аяныг эхлүүлж, төв зам дагуух газарт зүлэг, мод тарилаа. Цаашид мод, зүлгийн усалгаа, арчилгааг тогтмол хийж байхаар боллоо. Цахимаар аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний газар, ИНЕГ-ын харьяа Алтай нисэх буудал, “Говь-Алтай АЗЗА” ТӨХК-ийг тус аянд нэгдэхийг уриалж хөшөөний орчмыг цогцоор нь цэцэрлэгжүүлэх ажлыг эхлүүллээ.



Зураг 6 Ногоон байгууламж тарихын өмнө



Зураг 7 Ногоон байгууламж тарьсны дараа

Байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2 өрөө байранд иж бүрэн засвар хийлээ. Мөн байгууллагын албан тасалгааны цонх, хаалга сольсноор албан хаагчдын ая тухтай ажиллах дулаан орчин бүрдлээ.



Зураг 8 Засвар хийхийн өмнө



Зураг 9 Засвар хийсний дараа

Байгууллагадаа барих бидний бэлэг гэсэн урианд доор үйлчилгээний ажилчид албан тасалгаанд цэцэг байршуулах зорилгоор 3 цэцгийн тавиурыг өөрсдийн хүчээр хийлээ.



Зураг 10 Цэцгийн тавиур

7 БҮЛЭГ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААР

Монгол улсын Ерөнхий аудиторын төсвийн багцаас 2021 оны төсвийн жилд Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын урсгал зардалд 605.4 сая төгрөгийн санхүүжилт батлагдсан ба нь төрийн аудитын байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд бодитой

дэмжлэг болж төсвийн зарцуулалт, гүйцэтгэл, үр дүнг хуулийн дагуу тайлагнаж ажиллав. Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.18-д заасны дагуу Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын Төсвийн шууд захирагчийн үүргийг дарга бөгөөд тэргүүлэх аудитор гүйцэтгэж байна.

Төсвийн санхүүжилтийн, хэтрэлт, хэмнэлтийн талаар :

Тайлант жилийн 12 дугаар сарын 20-ны байдлаар 605.4 сая төгрөгийн санхүүжилт авахаар батлагдаж 605.4 сая төгрөгийн зарцуулах эрх үүсч, санхүүжсэн. Батлагдсан төсвийг зохих хууль журам, зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж нягтлан бодох бүртгэлийг хөтлөн санхүүгийн тайлан мэдээг зохих цаг хугацаанд нь гаргаж хэрэглэгч болон удирдлагыг санхүүгийн

мэдээллээр бүрэн ханган ажиллаж байна. Төсвийн үр ашигтай зарцуулалтад нягтлан бодох бүртгэлээр болон санхүүгийн тайлагналын хяналтыг хэрэгжүүлж ажиллалаа. Тайлант жилийн 12 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар төсвийн зарцуулалт 515.1 сая төгрөгийн буюу 85.0 хувийн гүйцэтгэлтэй байна. Энэ нь 2 аудитор хүүхэд асрах чөлөөтэй байсан тул цалингийн зардал хэмнэгдсэн байна.

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН 2021 ОНЫ ЖИЛИЙН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ХЭТРЭЛТ, ХЭМНЭЛТИЙН ТАЙЛБАР /сая.төгрөг/

№	Зардлын бүлгийн код	Зардлын бүлгийн нэр	Зарцуулах эрх		Төсвийн гүйцэтгэл		Төсвийн хэтрэлт, хэмнэлт	
			Урсгал төсөв	Эзлэх хувь	Урсгал төсөв	Эзлэх хувь	Зөрүү (+,-)	Эзлэх хувь
Урсгал зардлын тооцоо								
1	2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал	459.5	75.9	383.3	74.4	76.2	84.3
2	2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	59.7	9.9	46.2	9.0	13.5	15.0
3	2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22.2	3.7	21.7	4.2	0.5	0.6
4	2104	Хангамж, бараа материалын зардал	12.6	2.1	12.6	2.5	0.0	-
5	2106	Эд хогшил, урсгал засварын зардал	33.0	5.5	33.0	6.4	0.0	-
6	2107	Томилолт зочны зардал	6.9	1.1	6.8	1.3	0.1	0.1
7	2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	7.0	1.1	7.0	1.4	0.0	-
8	2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2.1	0.3	2.1	0.4	0.0	-
10	2132	Бусад урсгал шилжүүлэг	2.3	0.4	2.3	0.4	0.0	-
Урсгал зардлын дүн			605.4	100.0	515.1	100.0	90.3	100.0
Хөрөнгийн зардлын тооцоо								
Хөрөнгийн зардлын дүн			-		-		-	
НИЙТ ТӨСВИЙН ДҮН			605.4	100.0	515.1	100.0	90.3	100.0

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн талаар :

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангуулах, Төсвийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, төсвийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтын ил тод байдлыг хангах үүднээс өөрийн санхүүгийн үйл ажиллагааны зарцуулалтыг www.shilendans.gov.mn цахим хуудас болон байгууллагын мэдээллийн самбарт цаг хугацаанд нь бүрэн мэдээлсэн.

№	ХАМГААГАХ/ХАМГААГАХЫН ТӨЛӨӨЛӨГ	2020 ОНЫ 1-Р КВАРТАЛ				2020 ОНЫ 2-Р КВАРТАЛ				2020 ОНЫ 3-Р КВАРТАЛ				2020 ОНЫ 4-Р КВАРТАЛ				2020 ОНЫ БУСД			
		1-р кв	2-р кв	3-р кв	4-р кв	1-р кв	2-р кв	3-р кв	4-р кв	1-р кв	2-р кв	3-р кв	4-р кв	1-р кв	2-р кв	3-р кв	4-р кв	1-р кв	2-р кв	3-р кв	4-р кв
1	Дотоодын хөрөнгийн төлөвлөлт	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
2	Төсвийн бодлого, зарцуулалтын төлөвлөлт, зарцуулалтын хяналт, зарцуулалтын хяналтын үнэмлэхүй гүйцэтгэл	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
3	Төсвийн бодлого, зарцуулалтын төлөвлөлт, зарцуулалтын хяналт, зарцуулалтын хяналтын үнэмлэхүй гүйцэтгэл	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
4	Төсвийн бодлого, зарцуулалтын төлөвлөлт, зарцуулалтын хяналт, зарцуулалтын хяналтын үнэмлэхүй гүйцэтгэл	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
5	Төсвийн бодлого, зарцуулалтын төлөвлөлт, зарцуулалтын хяналт, зарцуулалтын хяналтын үнэмлэхүй гүйцэтгэл	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
6	Төсвийн бодлого, зарцуулалтын төлөвлөлт, зарцуулалтын хяналт, зарцуулалтын хяналтын үнэмлэхүй гүйцэтгэл	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
7	Төсвийн бодлого, зарцуулалтын төлөвлөлт, зарцуулалтын хяналт, зарцуулалтын хяналтын үнэмлэхүй гүйцэтгэл	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
8	Төсвийн бодлого, зарцуулалтын төлөвлөлт, зарцуулалтын хяналт, зарцуулалтын хяналтын үнэмлэхүй гүйцэтгэл	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
9	Төсвийн бодлого, зарцуулалтын төлөвлөлт, зарцуулалтын хяналт, зарцуулалтын хяналтын үнэмлэхүй гүйцэтгэл	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайланд өгсөн хараат бус аудиторын дүгнэлт

Манай байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд "Зөрчилгүй санал дүгнэлт" өгч 2.2 сая төгрөгийн өглөгийг барагдуулах 1 заалт бүхий зөвлөмжийг ирүүлсэн. Зөвлөмжийг хэрэгжүүлэх шийдвэрийн хэрэгжилтийг ЯАГ болон "Мишээл-Од" аудит ХХК-д хүргүүлсэн.

МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК
Нэгтгэл бодох бүртгэл, Аудит, Байгууллагууд, Аутсорсингийн үйлчилгээ, Бизнесийн зөвлөгөө өгөх

2021.04.05 № А/55

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймаг дахь төрийн аудитын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйцээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говь-Алтай аймаг дахь төрийн аудитын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдах эгтээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар Говь-Алтай аймаг дахь төрийн аудитын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйцэтгэний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Аудитын хүрээнд бусад асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа тусдаа дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг захиран эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Аудитын байгууллага захиран эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийлэлээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДББУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь захиран эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэгжлэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МИШЭЭЛ ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Т.ОДОНЧИМЭГ

2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр

8 БҮЛЭГ ДҮГНЭЛТ, САНАЛ

Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар нь 2021 онд дэвшүүлсэн “Аудитыг цахимжуулж, нэгтгэн удирдах тогтолцоог бүрдүүлэн төлөвшүүлэх” зорилтыг бүрэн хэрэгжүүлж ажиллалаа.



Тайлангийн нэр	Тайлангийн дугаар	Тайлангийн огноо	Тайлангийн хүрээ	Тайлангийн хүрээний хэмжээ	Тайлангийн хүрээний хэмжээний хүрээ	Тайлангийн хүрээний хэмжээний хүрээ	Тайлангийн хүрээний хэмжээний хүрээ	Тайлангийн хүрээний хэмжээний хүрээ	Тайлангийн хүрээний хэмжээний хүрээ
Тайлангийн нэр	Тайлангийн дугаар	Тайлангийн огноо	Тайлангийн хүрээ	Тайлангийн хүрээний хэмжээ	Тайлангийн хүрээний хэмжээний хүрээ	Тайлангийн хүрээний хэмжээний хүрээ	Тайлангийн хүрээний хэмжээний хүрээ	Тайлангийн хүрээний хэмжээний хүрээ	Тайлангийн хүрээний хэмжээний хүрээ

Дэвшүүлсэн зорилтын хүрээнд Шилэн дансны цахим хуудсанд 281 санхүүгийн тайлангийн аудитын шилэн дансны мэдээллийг оруулахаас 277 байгууллагын мэдээллийг бүрэн оруулсан, 4 байгууллагын мэдээллийг цахим системд шивэх цэс үүсгээгүй тул шивэгдээгүй

болно. Цахим системд хүний нөөцийн мэдээлэл бүрэн шивэгдсэн. Статистик мэдээний шивэлт хийгдэж байна.



Тайлант жилд хийсэн санхүүгийн тайлангийн аудит, өмнөх онуудын аудитаар өгсөн шийдвэрийг хэрэгжүүлэх, төрийн албан хаагчдыг ажлаас халж цалингийн нөхөн олговор олгосон асуудлыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төрийн өмнөөс төрийг төлөөлж асуудлыг шийдвэрлэх зорилгоор аймгийн Засаг даргын тамгын газар, Прокурорын газар, Цагдаагийн газартай хамтран ажиллаж байна.



АДБОУС-ыг Монгол Улсын “Төрийн аудит”-ын /MNS 6817:2020/ стандартын хүрээнд аудитын чанар, үр нөлөөг дээшлүүлэх зорилтыг хэрэгжүүлэн ажиллалаа.



Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар нь санхүүгийн тайлангийн аудитаар 198 санхүүгийн тайланд дүгнэлт өгч, 78 санхүүгийн тайланг түүвэрт хамруулж гүйцэтгэлийн 4 аудит хийж аудитаараа 49,738.8 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналтай холбоотой 6,740.1 сая төгрөгийн зөрчлийг залруулж 11,169.7 сая төгрөгийн зөрчилд 845 албан шаардлага, 30,913.0 сая төгрөгийн зөрчилд 267 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлж, 910.9 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож 68 албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлагыг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлсэн байна.



Орон нутгийн төсөвт 2,338.6 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, 37,019.1 сая төгрөгийн үр өгөөжийг хүлээн зөвшөөрүүлсэн нь төсвийн санхүүжилтийн “Нэг” төгрөг тутамд 61.15 төгрөгийн үр өгөөж бий болсон байна.

Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын зүгээс дараах санал, хүсэлтийг хүргүүлж байна. Үүнд:

- ✓ Нэгдсэн удирдамжаар хийсэн аудитаар өгсөн саналыг хэрхэн шийдвэрлэсэн талаар орон нутагт мэдэгдэж байх
- ✓ Нэгдсэн удирдамжаар хийж байгаа аудитын талбарын ажил хийх хугацааг нэмэгдүүлэх, түүвэрт хамруулах хэмжээ, цар хүрээг тогтоож өгвөл, аудитын чанар, үр өгөөж дээшлэхээр байгааг анхаарч үзэх
- ✓ Тусгай сангаас иргэд, аж ахуйн нэгжид олгосон зээлийн мэдээллийг Монгол банкны зээлийн мэдээллийн санд оруулах асуудлыг нэгдсэн байдлаар шийдвэрлэх.
- ✓ Төрийн аудитын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т “Төрийн аудитын үндсэн зорилт нь төрийн санхүү, төсөв, нийтийн өмчийг хууль ёсны дагуу арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэйгөөр төлөвлөх, хуваарилах, ашиглах, зарцуулахад хяналт тавих, түүнчлэн төрийн санхүүгийн удирдлагыг сайжруулж, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ”, Прокурорын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-т “Прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр, нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлт, эсхүл өөрийн санаачилгаар захиргааны болон иргэний хэрэг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаанд зохигчоор, эсхүл гуравдагч этгээдээр оролцоно” гэж заасан. Дээрх чиг үүргийн хүрээнд Төрийн аудитын байгууллага, Прокурорын байгууллагууд нь төрд учруулсан хохирлыг төлүүлэх чиглэлээр хамтран ажиллах боломжтой байна. Иймд холбогдох төрийн байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх
- ✓ Шүүхийн шийдвэрийн дагуу байгууллагын цалингийн сангаас олгосон цалингийн нөхөн олговрыг нэхэмжлэн төрийг хохиролгүй болгох ажлыг нэгдсэн байдлаар шийдвэрлэх
- ✓ Төрийн аудитын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-т “Төрийн аудитын байгууллага хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг Захиргааны ерөнхий хуулийн 82, 83 дугаар зүйлд заасан журмаар гүйцэтгэнэ” гэж заасан боловч нарийвчилсан зохицуулалтгүй, хэрхэн гүйцэтгэх нь тодорхойгүй байгаа тул нэгдсэн байдлаар заавар журмаар хангах

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



Говь-Алтай айман дахь Төрийн аудитын газар
/Есөнбулаг сум Баянхайрхан баг/



www.audit.mn



70483413